



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/141

Номгон

Мэргэжлийн Боловсрол сургалтын Үндэсний
зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.3, Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Мэргэжлийн Боловсрол сургалтын Үндэсний Зөвлөлийн 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн Боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн Орон нутгийн салбарын зөвлөлийн удирдлагыг томилох, гишүүнийг сонгох, баталгаажуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга: Г.Энхбаяр -Аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч

Дэд дарга: Н.Одончимэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Бат-Орших -Политехник коллежийн захирал

Гишүүд: А.Өлзийжаргал-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

Ц.Энхтөр- Боловсрол, соёл, урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ж.Дуламсүрэн- Ажил олгогч эздийн холбооны дарга

Г.Энхтүвшин-Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

Ч.Сүнжидмаа- Ажил олгогчдын төлөөлөл /”Навтгар хайрхан” ХХК-ний ерөнхий инженер/

Т.Бат-Ирээдүй -Багш, ажиллагсдын төлөөлөл /Сургалтын албаны менежер/

1210361

2.

2.Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл нь Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн 2010 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн Боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”-ийг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

3.Мэргэжлийн боловсрол сургалтын Орон нутгийн салбар зөвлөлийн ажлыг дүрэмд заасан чиг үүрэг, үйл ажиллагааны дагуу хэрэгжүүлж, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг орон нутгийн салбар зөвлөлийн дарга /Г.Энхбаяр/-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Өнөржаргал/-д даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2017 он А/213 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН